

Батлав:



МХТС-ийн захирал доктор, дэд проф. Н.Чулуунбанди

## **МХТС-ийн нэрэмжит УЛСЫН “Инженерчлэлийн эдийн засаг”-ийн III НЭЭЛТТЭЙ олимпиадын удирдамж**

### **Нэг. Үндэслэл**

“Инженерчлэлийн эдийн засаг” – F.CN104 хичээлийн сургалтад тус сургуулийн бүх мэргэжлийн оюутнууд хамрагддаг бөгөөд намрын улиралд электроникийн салбараас бусад бүх мэргэжлийн ихэвчлэн II курсын 500 гаруй оюутнууд уг хичээлийг үзэж судалдаг. Электроникийн салбарын оюутнууд хаврын улиралд үздэг. Цаашдаа ШУТИС-ийн бусад бүрэлдэхүүн сургуулиудын бүх инженер-технологийн мэргэжлийн оюутнууд энэ хичээлийг үздэг болох нь зүйтэй юм. Иймд “Инженерчлэлийн эдийн засаг”-ийн энэхүү олимпиадыг жил бүр МХТС-ийн нэрэмжит болгон хичээлийн жил бүрийн намрын улиралд Холбооны салбар (F.CN104 хичээлийг заадаг багш нар) хариуцан зохион байгуулна.

### **Хоёр. Зорилго**

Инженерийн чиглэлээр суралцагч оюутан нь инженерчлэлийн эдийн засгийн мэдлэгтэйгээр сайн инженер, сайн мэргэжилтэн болох тул тэдний идэвх сонирхлыг сайжруулах, “Инженерчлэлийн эдийн засаг” хичээлээр авсан мэдлэгийг өргөтгөх, бататгах, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, чадвар дадал олгоход олимпиадын зорилго оршино.

Цаашдаа улам бүр цар хүрээг нь тэлж, оролцогч сургуулийн мэргэжлийн багш нар туршлагаа солилцдог, оюутнууд мэдлэг чадвараа сорьдог улсын хэмжээний тогтмол зохион байгуулагддаг олимпиад болгох зорилготой.

### **Гурав. Олимпиад зохион байгуулах журам**

3.1 Уг удирдамжийн дагуу Инженерчлэлийн эдийн засгийн улсын III олимпиадыг их, дээд сургуулиудын оюутнуудын дунд нээлттэй зохион байгуулна.

3.2 Олимпиадыг хоёр үе шаттай зохион байгуулна.

3.2.1 МХТС сургуулийн оюутнуудын дунд I үе шатыг онлайн хэлбэрээр хичээлийн жилийн намрын улирлын эхний явцын шалгалттай хавсарч 2022 оны 10 дугаар сарын 17-21-ны өдрүүдэд зохион байгуулна.

- 3.2.2 Олимпиадад оролцох бусад сургуулийн оюутнуудын I шатны сонгон шалгаруулалтыг тухайн оролцогч сургуулийн багш нар сургууль тус бүр дээр удирдан зохион байгуулна.
- 3.2.3 II үе шат 2022 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр МХТС дээр танхимаар зохион байгуулна. Оролцож байгаа их дээд сургуулиуд өөрсдийн шалгаруулсан оюутнуудыг II шатанд оруулахаар бүртгүүлж, мандатаа авсан байна.
- 3.2.4 Олимпиадын II үе шатыг танхимаар зохион байгуулж байгаатай холбоотойгоор халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллана.
- 3.2.5 Олимпиадтай холбоотой асуудлыг ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуулийн Холбооны салбарын 70156333 болон 80084583 (ахлах багш Ч.Оюу) утсаар ажлын цагаар лавлаж болно.

#### **Дөрөв. Шалгаруулалт, шагнал урамшуулал**

- 4.1 I үе шатад 9-өөс дээш оноо авсан оюутнууд 2-р шатанд орж болно. Олимпиадад оролцох оюутны тоонд хязгаарлалт тавихгүй.
- 4.1.1 Өмнө нь F.CN104 хичээлийг үзэж, А үнэлгээ авсан тус сургуулийн оюутнууд II шатны шалгаруулалтанд оролцож болно.
- 4.1.2 Олимпиадад оролцох бусад сургуулийн оюутнуудын сонгон шалгаруулалтыг тухайн сургуулийн багш нар удирдан зохион байгуулна. Эдийн засгийн онол, Санхүүгийн болон Төслийн менежмент судалсан бусад сургуулийн оюутнууд хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож болно.
- 4.2 II үе шат 2022 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр МХТС дээр танхимаар зохион байгуулна.
- 4.2.1 II шатанд шалгарсан оюутнууд 2022 оны 11 сарын 18-ны 17 цагаас өмнө ШУТИС МХТС-ийн 216 болон 306 тоотод иргэний үнэмлэхийн хуулбар, сургуулийн тодорхойлолт, цээж зургийн хамт авчирч баталгаажуулалт хийж, мандатаа авна. Заасан хугацаанд баталгаажуулалт хийгээгүй оюутнуудыг II шатны бүртгэлээс хасна.
- 4.2.2 Оролцож байгаа их дээд сургуулиуд өөрсдийн шалгаруулсан оюутнуудыг II шатанд оруулахаар бүртгүүлж, мандатаа авсан байна. Мандат авахдаа 4.2.1 заалтыг баримтална уу.
- 4.3 II шатнаас нэгдүгээр байр 1, хоёрдугаар байр 2, гуравдугаар байр 2, тусгай байранд 5 оюутан шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.



I байр	Нэг	Тус бүр 100 000₮, өргөмжлөл
II байр	Хоёр	Тус бүр 80 000₮, өргөмжлөл
III байр	Хоёр	Тус бүр 60 000₮, өргөмжлөл
Тусгай байр	Тав	Тус бүр 30 000₮, өргөмжлөл

4.3.1 Байр эзлүүлэхдээ оноогоор дүгнээд онооны дарааллаар байр эзлүүлнэ.

4.3.2 Оноо тэнцсэн тохиолдолд эхний шатны шалгаруулалтын оноог харгалзан үзнэ.

4.4 Мөн олимпиадын II шатанд оролцож, авбал зохих нийт онооны 70 –аас дээш хувийг авсан оюутнуудад батламж өгөхийн зэрэгцээ 2-р явцын шалгалтын болон улирлын шалгалтын оноог шууд тооцож болно.

#### **Тав. Зохион байгуулах комисс**

5.1 Зохион байгуулах комисст МХТС-ийн “F.CN104 Инженерийн эдийн засаг” хичээлийг зааж байгаа багш нар орно.

5.2 Олимпиадад оролцож байгаа сургуулиудын багш нар зохион байгуулах комисст орж ажиллах эрхтэй.

5.3 Шалгаруулалтад Инженерчлэлийн эдийн засгийн асуудал шийдвэрлэсэн тест, бодлого бүхий даалгаврууд орно.

5.4 Олимпиад зохион байгуулах комисс нь шалгаруулалтын тест, бодлогыг багш нараас дэвшүүлсэн хувилбаруудаас сонгох замаар боловсруулж бэлтгэх ба нууцыг хадгална.

5.5 Багш нар оюутнуудаа олимпиадад бэлтгэж оролцуулах ба шалгаруулалтын тест, бодлогыг боловсруулж дэвшүүлэх, комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах эрхтэй.

5.6 Тухайн хичээлийн жилд “Инженерчлэлийн эдийн засаг”-ийн олимпиадыг зохион байгуулах комисс болон төсвийг захирлын тушаалаар баталгаажуулна.

**Олимпиадыг зохион байгуулагч: МХТС-ийн Холбооны салбар**